

ШИНЭ ЦАГ ҮЕ, ШИНЭ ХАНДЛАГА, ШИНЭ СЭТГҮҮЛ ЗҮЙ
(Олон улсын сэтгүүл зүйн зарим асуудал)

Б. Болд-Эрдэнэ*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, доктор (PhD), дэд профессор

Түлхүүр үг: олон улсын сэтгүүл зүй, үндэсний эрх ашиг, дэлхийн нийгэм, даяарчлал, гадаад бодлого, мэдээллийн бодит байдал.

Олон улсын сэтгүүл зүй хэмээх нэр томъёо ойлголт ХХ зуунаа жинхэнэ утгаараа төлөвшин хөгжсөн нь нэг талаас их гүрнүүдийн эрх ашиг байр суурь олон улсын харилцаанд бодитой нөлөөлөх болсон нөгөө талаас дэлхийн нийгмийн даяарчлалын хүрээ өрнөл өсөн нэмэгдсэнтэй холбоотой гэдэг. Нэн ялангуяа хүйтэн дайны үеийн үзэл суртал, социалист капиталист ертөнцийн сөргөлдөөн нь мэдээллийн сонголт, илэрхийлэл, болоод харилцаанд гүн гүнзгий нэвчин суртал ухуулга, үгүйсгэл, туйлшралын орон зайг хөхүүлэн тэтгэж байсан нь бусад сэтгүүл зүйн шинж төлөвөөс эрс өөрөөр тодорхойлох зайлшгүй нөхцөл хандлагыг бий болгожээ.

Гэхдээ 1990-ээд оноос дэлхий нийгэм, олон улсын харилцаанд сөрөн эсэргүүцэх, үл итгэх, заналхийлэх хандлага үгүй болж, харилцан ойлголцох, олон ургальч үзэл бодол, байр

суурийг дээдлэх болсноор мэдээллийн орон зайд урьд өмнө байгаагүй боломж, өнгө төрхийг бий болгосон нь олон улсын сэтгүүл зүйн мөн чанар, үүрэг зорилгыг шинэчлэн үзэх шалтгаан болсон юм. Үүнийг томъёолбол **олон улсын сэтгүүл зүй нь дэлхийн нийгэм, улс орнуудын үйл явдал үзэгдэл тулгамдсан асуудлын тухай мэдээллийг үндэсний язгуур эрх ашгийн үнэлэмж, үзэл санааны үүднээс хүлцэн тэвчих, хүмүүнлэг эш байдалд тулгуурлан түгээх зорилго бүхий харилцаа** хэмээх болов. Өөрөөр хэлбэл олон улсын сэтгүүл зүйг дэлхийн нийгмийн харилцаа хэмээн тодорхойлох болсон нь улс төр-үзэл суртлын хүлээс, хатуу чанд хязгаарлалтаас хүлцэн тэвчихгүй, даяарчлал уруу, марксист ангич намч хандлагаас иргэншил, улс үндэстний эрх ашгийн тайлбар уруу, нэг талын, тулган шахалтын сэтгэхүйгээс олон ургальч, харилцан ойлголцол уруу мэдээллийн орон зайн хувьсал төлөв байдал бүрэлдсэн гэсэн үг. Энэхүү олон улсын сэтгүүл зүйн шинэ төлөв байдалд нөлөөлөгч олон хүчин зүйл, үндэслэл шалтгаан бий боловч

тэдгээрийг нэгтгэн зургаан хүрээнд авч үзсэн нь бий. Үүнд шинэ түүхэн цаг үе, шинэ улс төрийн газрын зураг, даяарчлагдсан сэтгэхүй төсөөлөл, сэтгүүл зүйн шинэ агуулга, эрмэлзлэл бол хэрэглэгчид (үзэгч, сонсогч, уншигч. **зох**) эдгээр болно¹ гэжээ. Үнэхээр ч хүйтэн дайны үед АНУ, ЗХУ гэсэн хоёр том гүрэн, хоёр сөргөлдөгч тогтолцооны үзэл суртал, номлолоор олон улсын амьдралын үйл явдал үзэгдлийг тайлбарлаж дүгнэж байсан нь дэлхийн мэдээллийн орон зайн өнгийг дэндүү гэнэн хялбараар "будаж" асуудлын учир шалтгаан, мөн чанарыг бус харин хэлбэр, билэгдэл талаас нь тодорхойлж, үгүйсгэл, туйлшрал, магтаалын сэтгүүл зүй болохын үндэс шалтгаан болов. Ийм жишээ хандлага монголын сэтгүүл зүйн өнгөрсөн төдийгүй өдгөө цаийн агуулга "сэтгэхүйд" оршсоор байна. Үүнийг ерөнхийд нь манай олон улсын сэтгүүл зүй капитализмийн үгүйсгэлээс капитализмийн магтаал болжээ хэмээн нэгтгэн дүгнэж болохоор байна.

Үнэхээр бид социалист интернационализмийг даяарчлалаар, ЗХУ-ыг АНУ-аар, социалист орнуудын ололт амжилтыг ертөнцийн дуулиан шуугианаар, социалист хамтын ажиллагааг хандивлагч орнуудын зээл тусламжаар сольсноос өөр өөрчлөлт үгүй олон улсын сэтгүүл зүйтэй л боллоо. Гэтэл

монголын нийгэм, хэрэглэгчдэд үндэсний эрх ашиг, сонирхлыг дэлхийн нийгмийн шинэ дэг журамд бодитой үнэлж дүгнэгч сэтгүүл зүй юу юунаас чухал гэдэг нь ойлгомжтой. Энгийнээр хэлбэл манай олон улсын сэтгүүл зүй нь дэлхий ертөнцийг харах монгол "цонх" байх ёстой. Энэхүү мэдээллийн эрэлт хэрэгцээ ч болж өнгөрсөн АНУ-ын ерөнхийлөгч Жорж Бушийн Монголд хийсэн айлчлалын үеэр бүр их мэдрэгдэж байлаа. Энэхүү түүхэн

үйл явдлыг нэгдүгээрт дэлхийн нийгмийн шинэ дэг журам, бодит байдалд хэрхэн тодорхойлох, хоёрдугаарт үндэсний эрх ашиг, тусгаар тогтнол аюулгүй байдлын үүднээс ямар ач холбогдолтой болох, гуравдугаарт өнөөгийн олон улсын тулгамдсан асуудал, үйл

явдлын хүрээнд хэрхэн холбон тайлбарлах, дөрөвдүгээрт монголд хандаж буй их гүрнүүдийн стратеги бодлого мөн чанарт үнэлэлт өгч ямар онцлог, боломж нөхцөл бий болсныг томъёолох, эцэст нь Монгол Улсын гадаад бодлого, байр суурийн өнөө болоод хэтийн төлөв байдлыг нэгтгэн тодорхойлох зайлшгүй шаардлага эрэлт хэрэгцээ манай телевиз, радио хэвлэл мэдээллийнхний өмнө байсан юм. Өөр нэгэн чухал сонирхолтой асуудал нь манай хоёр том хөршийн байр суурь, хандлага, АНУ-ын ерөнхийлөгчийн Азид хийсэн айлчлалын

«

***Монголын нийгэм, хэрэглэгчдэд
үндэсний эрх ашиг, сонирхлыг
дэлхийн нийгмийн шинэ дэг журамд
бодитой үнэлж дүгнэгч сэтгүүл зүй
юу юунаас чухал гэдэг нь
ойлгомжтой. Энгийнээр хэлбэл
манай олон улсын сэтгүүл зүй нь
дэлхий ертөнцийг харах монгол
"цонх" байх ёстой.***

»

зориулалт учир холбогдол, АНУ-ын Ази тивд явуулж буй бодлогын уламжлал шинэчлэл зэрэг цогц хүрээнд айлчлалын талаархи тайлбар дүгнэлтийг хүргэх нь чухал байлаа. Гэвч АНУ-ын ерөнхийлөгчийн эхнэртээ зориулсан шүлгийн орчуулга, ямар машин, хэдэн онгоцтой ирсэн, юу амалсан, хэн юу гэж магтсан, хэдэн хүн хамгаалсан гээд "тулга тойрсон", бие биенээ давтсан үг яриагаар манай сэтгүүл зүй үүргээ биелүүллээ. Өөрөөр хэлбэл, олон улсын сэтгүүл зүйг төрөөр тэтгүүлдэг, төрд бүхнээ даатгадаг үзэл санааны монгол сэтгүүл зүй болголоо гэсэн үг. Ер нь манай гадаад мэдээ нийтлэл нэвтрүүлэг нь улс орны онцлог хөгжил дэвшлийн магтаал болоод байгаль ертөнцийн байдал эсвэл дайн байлдаан хямрал зөрчил, гэмт хэргийн сонин хачин болоод байгаа нь олон улсын сэтгүүл зүйн гажуудал гэхээр үзэгдэл билээ.

Олон улсын сэтгүүл зүйн өөр нэгэн чухал зүйл нь мэдээллийн үнэлэмжийн асуудал юм. Үүнийг газар зүйн утга нөлөөлөөр тодорхойлбол европын сэтгүүл зүйд үндэсний, европын, дэлхийн, харин америкийн хувьд нэгдүгээрт эдийн засгийн эрх ашиг сонирхол бүхий бүс нутаг улс орны, хоёрдугаарт, улс төрийн нөлөө байр суурь бүхий бүс нутаг улс орны, гуравдугаарт соёл нийгмийн ач холбогдол бүхий бүс нутаг улс орны үйл явдал асуудлын мэдээ мэдээлэл хэмээн үздэг байна. Харин монголын олон улсын сэтгүүл зүйн тэргүүн зэргийн ач холбогдол хүрээ нь **нэгдүгээрт өмнө хойд хоёр том хөршийн, хоёрдугаарт эдийн засгийн нөлөө, дэмжлэг үзүүлэх улс орны, гуравдугаарт дэлхийн нийг-**

мийн тулгамдсан, зөрчилт асуудал хэмээн ангилж болмоор санагдана.

Олон улсын сэтгүүл зүйн орон зайд мэдээллийн сонголт, ач холбогдол, үнэлэмжийн асуудал нь үндэсний эрх ашиг, эдийн засаг, улс төрийн нөлөө, сонирхол, газарзүйн хамаарал гэсэн үндсэн шалгуур үзүүлэлтээр тодорхойлогддог гэдэг. Тэр дундаа манай олон улсын мэдээллийн үнэлэмжийн хувьд үндэсний эрх ашиг нь тэргүүн зэрэгт тавигдах шалгуур юм. Үндэсний эрх ашиг нь нийгмийн ухамсар болохынхоо хувьд тодорхой асуудал, улс орон, үйл явдлын хүрээнд өөрчлөгдөн хувьсч байдаг олон нийтийн санаа бодол хандлага юм. Харин олон улсын харилцааны хувьд үндэсний эрх ашиг нь тусгаар тогтнол аюулгүй байдлын эрэлт хэрэгцээ, зайлшгүй үр дагавар нөхцөлөөр тодорхойлогддог үзэл баримтлал болой. Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлалд "... үндэсний язгуур ашиг сонирхолд монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдал, эдийн засгийн харьцангуй бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил, үндэсний эв нэгдэл багтана" хэмээн заажээ. Энэхүү үзэл баримтлалын хүрээнд манай сэтгүүл зүйн гадаад мэдээллийн чухал, онцгой агуулга, объект нь дэлхийн нийгэм эдийн засаг улс төрийн тогтолцоонд нөлөө бүхий Орос Хятад хэмээх хөрш гүрэн болох нь тодорхой. Энгийнээр хэлбэл, Монгол орон монголчуудын эрх ашиг сонирхолд хамгийн нөлөө бүхий, шууд хамааралт,

зайлшгүй хүчин зүйл нь хоёр том хөрш байна гэсэн үг. Тиймээс ч Монгол Улсын гадаад Бодлогын үзэл баримтлалд "ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд аль нэгийг нь өрөөсгөлөөр дагахгүй бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хамтын ажиллагааг хөгжүүлнэ. Чингэхдээ энэ хоёр оронтой харилцаж ирсэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагаа өвөрмөц онцлогийг харгалзана" гэж тодорхойлжээ. Үүнийг сэтгүүл зүйн хэлээр "орчуулбал" ОХУ, Хятадын эдийн засгийн төлөв байдал хөгжил, тулгамдаж буй асуудлыг улс төр, соёл, шинжлэх ухааныхаас илүү бодитой өргөн хүрээнд мэдээллээс тайлбарлах нь манай олон улсын нийтлэл нэвтрүүлгийн үндсэн зорилго ажээ. Гэхдээ хятадын эдийн засгийн өсөлт хөгжлийн тухай магтан бишрэх, эсвэл айн сэрэмжлэх бус харин энэхүү зах худалдаа, орон зайд Монгол Улс хэрхэн байр сууриа олох, ямар боломж нөхцөл буй, тулгамдсан зөрчилт, бэрхшээлт асуудал юу болох зэрэг хандлага үнэлэмжээр мэдээллийн сонголт үзэл бодлын суурь тулгуураа тодорхойлох жишээтэй. Харин Оросын үйл явдал амьдралын хувьд бидэнтэй адил ойролцоо асуудал бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэж байгаа Монголын эдийн засаг гадаад худалдааны орчинд шууд нөлөөлөх нефть, шатахуун эрчим хүчний зах зээлийн бодит байдал, түүнд нөлөөлж буй улс төр нийгмийн хүчин зүйл, хамтын ажиллагааны шинэ боломж нөхцөл, уламжлалт бусад харилцааны хүрээний өргөжилт зэрэг хүрээнд мэдээллийн орон зайгаа тодорхойлох хэрэгтэй. Энэхүү үнэ-

лэмж, шалгуур нь монголын нийгэм, үзэгч, уншигчдын эрэлт хэрэгцээ, сонирхол төдийгүй олон нийтийн санаа бодлыг төлөвшүүлэх зорилгыг тодорхойлогч мөрдлөг билээ. Мэдээж үүнд нийгмийг чухал зайлшгүй мэдээллээр хангах, олон улсын сэтгүүл зүйн мөн чанар учир шалтгаан оршино. Харамсалтай нь энэхүү үнэлэмж хандлагаар бол монголын сэтгүүл зүй нь орчуулгын, дамжуулагчийн байр суурь, төлөв байдлаар хандсаар байна. Тодруулбал оросын нийгэм үзэгч уншигчдад улс орных нь дотоод амьдрал, үйл явдлыг мэдээлсэн агуулгыг монголчуудад орчуулан хүргэж байна гэсэн үг. Харин Хятадын тухай мэдээлэл нь ихэвчлэн төр засгийн, албаны эх сурвалж, үзэл санаа давамгайлж буй нь Монголын нийгмийн мэдээллийн эрэлт хэрэгцээтэй нийцэхгүй нь тодорхой. Ийнхүү нэгтгэн тодорхойлолбол манай хоёр ах хөршийн тухай мэдээлэл нь өнөөгийн бодит шаардлага эрэлт хэрэгцээтэй харьцуулбал дэндүү бага байна гэсэн гаргалгааг хийж болно.

Мэдээллийн үнэлэмж шалгуурын хоёр дэх төвшин болох эдийн засгийн нөлөө дэмжлэг үзүүлэх улс орны тухай мэдээлэх асуудал ч учир дутагдалтай байна. Энд ерөнхийдөө өмнө өгүүлсэн бусдаар тэтгүүлэх, бусдад бүхнээ даатгах сэтгэхүй, тусламж зээлийн тухай магтаал, "мөрөөдөл" ноёрхож байгаа нь нууц биш. Ийм нэгэн жишээ нь америкийн засаг захиргааны мянганы сорилтын сангаас тусламж авах эрх бүхий орнуудын тоонд Монгол улс багтсан тухай сүр дуулиан юм. Энэхүү "горьдлого" ч Жорж Бушийн айлчлалаас манай сэтгүүл зүйн хүсэн

хүлээж байсан хамгийн чухал сэдэв агүүпга байсан юм. Хэдийгээр энэ тухай АНУ-ын ерөнхийлөгч яг тодорхой амлалт өгөөгүй ч монголын телевиз радио сонин хэвлэл, өөрсдийн сэтгэхүй үгээр тусламж "бүтлээ" хэмээн зарлаж чадсан юм. Гэтэл бодит байдалд айлчлалаас хойш 9 сарын дараа асуудал тодорхой болох талаар монголын албаны хүмүүс ч тайлбар өгсөөр байгаа билээ. Түүнчлэн уг айлчлалын талаарх мэдээллийг шинжилж байхад манай сэтгүүлчид өөрсдийгөө "магтах" өвчин туссан юм уу даа гэмээр эргэцүүлэл төрж байв. Гэхдээ нөгөө талаас бодоход үйл явдал, асуудлын талаар "бага" мэдлэгтэй хүн өөрийгөө ярихаас өөр юу бичиж хэлэх вэ дээ гэсэн санаа төрснөө нуугаад яах вэ... Тиймээс олон улсын мэргэжлийн сэтгүүлч, тоймчдийг онцгойлон анхаарч бэлтгэх, сургах тодорхой бодлого үйл ажиллагаа явуулах цаг нэгэнт болжээ. Ер нь гадаадынханы эсрэг үг үзэл бүр хөдөлгөөн манай нийгэмд хүчтэй өрнөн хүчирхийлэлд хүртлээ тэсэрсэн нь олон улсын сэтгүүл зүйн өрөөсгөл, учир дутагдалтай мэдээлэл түгээж байгаатай ямар нэг холбоотой гэдэг нь тодорхой. Ер нь логик, бодит утгаараа бол "бидэнд үнэгүй юм өгдөг" улс орон гэж үгүй болох нь мэдээж. Гэтэл энэхүү энгийн үнэнийг монголын сэтгүүл зүй хэлж чадахгүй л байна. Тэр бүү хэл ерөнхийлөгч Н.Энхбаяр АНУ-ыг "гуравдах хөрш" гэж хэмээн онцолсон нь ч үндэсний эрх ашиг, эдийн засгийн харилцааны утгаар бус харин нөгөө л тусламж хүсэлтийн сэтгэхүйн зөрчилт мэдэгдэл атал бас л сэтгүүл зүйн "нүд чихнээ" өртсөнгүй. Маш тодорхой үнэн бол монголчуудын хувьд эрх ашиг

сонирхол эдийн засгийн гуравдах түнш бол АНУ-аас илүү Япон, Солонгос гэдэг нь хэнд ч ойлгомжтой зүйл төдийгүй НҮБ, Зүүн өмнөд Азийн хамтын ажиллагааны байгууллага, Шанхайн нийгэмлэг гээд нөлөө байр суурь бүхий олон олон улсын субъект буйг үл мэдсэн мэдэгдэл байлаа. Гэтэл энэ талаар манай сэтгүүл зүй нэг ч үг дуугараагүй нь бидний бодит том дутагдал мөн. Ер нь манай олон улсын сэтгүүл зүй төр засгийн гадаад бодлого үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, шүүн тунгааж, шүүмжилж байх үүргээ умартсан бололтой. Өөрөөр хэлбэл гадаад мэдээ мэдээллийг ч, дотоод бодлого үйл явдлыг ч үндэсний эрх ашиг, аюулгүй байдал, тусгаар тогтнол, үр ашигтай хамтын ажиллагааны үнэлэмж шалгуураар шүүн тодорхойлох үүрэг холбогдол олон улсын сэтгүүл зүйд үгүйлэгдсээр байна.

Харин олон улсын мэдээллийн гуравдах төвшин болох дэлхийн нийгмийн тулгамдсан, зөрчилт үйл явдал асуудлын тухай мэдээлэл байдал илүү "гэгээлэг" байна. Өөрөөр хэлбэл цаг үеийн, томоохон, чухал үйл явдал үзэгдэл асуудлыг мэдээллэх үүргээ манай сэтгүүлчид харьцангуй сайн биелүүлж байна. Гэхдээ энэ нь бидний сайных бус харин мэдээллийн даяарчлал, дэлхийн телевиз, интернетийн сүлжээний нээлттэй орон зайн ач буян билээ.

Өөр нэгэн тэмдэглэвэл зохих зүйл нь олон улсын мэдээлэлд ертөнцийн болоод дэлхийн нэр хүндтэй олны танил хүмүүсийн тухай сонин хачин дуулиан шуугиан багагүй хувийг эзэлж байгаа явдал юм. Энэ нь нэг талаар олон нийтийн сонирхол, тодорхой хүрээний эрэлт хэрэгцээ мөн боловч

нөгөө талаар сонин хэвлэлийн гадаад мэдээллийн ихэнхи зай, телевизийн цагийг эзэгнэх агуулга байх нь хүлээн зөвшөөрөхүйц үзэгдэл бас биш ээ. Тэгээд ч сүүлийн үед манай олон улсын сэтгүүл зүйд дээрх мэдээлэл хүч түрэн буй нь зүй бус, "муу" хандлага болой. Хэн нэгэн нөхрөөсөө салсан, цацагт хяруул идэх уралдаанд түрүүлсэн, Гиннесийн номонд бичигдсэн, шинэ тоглолт хийх болсон, кино найруулагчтайгаа муудалцсан, байшин худалдаж авсан зэрэг нь тийм чиг чухал мэдээлэл биш нь ойлгомжтой бөгөөд монголын нийгэмд ямар ч ач холбогдол, нөлөөгүй асуудал юм.

Нийгмийн оюун санаа мэдээллийн тогтолцоо, харилцаа болохынхоо хувьд олон улсын сэтгүүл зүй нь бодит үнэн, баримт мэдээлэл үзэл санаа агуулга цогц байх ёстой билээ. Тэр дундаа олон улсын үйл явдал, асуудлыг боловсрол мэдлэг, нийгмийн байр суурь, амьдрал ахуйн хувьд дээд төвшний бүлэг хүрээ сонирхдог ба тэдний эрэлт хэрэгцээ хандлага нь зөвхөн мэдэх мэдээлэл авах бус харин өөрийн байр суурь, үзэл бодлоо харьцуулах, бусдад илэрхийлэх нотлон баяжуулахад оршдог учир үнэлэмж, шаардлагын төвшин өндөр дээд болно. Тиймээс ч олон улсын сэтгүүл зүйг "элит" сонгодог, хэмээн тодорхойлдог. Тэгээд ч уншигчдын чанар, олон улсын

асуудлыг задлан шинжилж тайлбарладагаараа америкийн "Нью Йорк Таймс", английн "Таймс", германы "Ди Велт", францын "Ле Монд" зэрэг сонин элит сонгодог хэвлэл хэмээгддэг. Дэлхийн телевиз болох CNN, FOX, BBC, NBC зэрэг нь ч дэлхий дахины томоохон чухал үйл явдал үзэгдлийг үзүүлдэгээрээ нөлөө байр сууриа тодорхойлдог. Ер нь дэлхийн мэдээллийн бизнесийн өрсөлдөөн, ноёрхлын гол утга нь нэгдүгээрт бодит үнэн, хоёрдугаарт шуурхай байдал билээ.

Даяарчлал, дэлхийн шинэ дэг журам, иргэншил хоорондын зөрчил, эдийн засгийн интеграчлал зэрэг орчин үеийн олон улсын харилцааны мөн чанар нь сэтгүүл зүйг илүү хариуцлагатай, тэнцвэртэй, үзэл сурталгүй

«
*Даяарчлал, дэлхийн шинэ дэг
журам, иргэншил хоорондын
зөрчил, эдийн засгийн интеграчлал
зэрэг орчин үеийн олон улсын
харилцааны мөн чанар нь сэтгүүл
зүйг илүү хариуцлагатай,
тэнцвэртэй, үзэл сурталгүй
мэдээллийн харилцаа байх нөхцөл
шалтгаан нь болж байна.*

»

мэдээллийн харилцаа байх нөхцөл шалтгаан нь болж байна. Сэтгүүл зүйн онолын томоохон төлөөлөгч Харолд Лассуел бодит үнэн нь нэгдүгээрт "баримтад үндэслэсэн" хоёрдугаарт "үнэлэмжийг агуулсан"²-аар тодорхойлогдоно гэжээ. Түүнчлэн "Сэтгүүлчид бодит байдлыг дээдлэн, үзэл бодлоо үйл явдлаас ангид үзэн хязгаарлах нь зүйтэй"³ гэсэн Америкийн томоохон судлаач У.Липман тэмдэглэсэн байх юм.

Олон улсын үйл явдал, амьдралын хүрээнд бодит мэдээллийн асуудал нь үзэл суртал, сэтгэл хөөрөл,

шууд дүгнэлт, хэтрүүлээс ангид байж, бодит баримт, үр дагавар, шалтгаанд үндэслэгдсэнээр сая бодит зүйл болно.

Этэл өнөөгийн монголын сэтгүүл зүйн жишээ жишигт олон улсын асуудал нь улс төр, үзэл суртлын сурталчилгаа болох, нэр хүнд, байр суурь, үзэл бодлоо тулгах нотолгоо мэтээр ашиглах төдий хүрээнд оршин байна. Ерөнхийлөгч Жорж Бушийн айлчлалыг л гэхэд ардчиллын баталгаа хөгжил дэвшлийн нотолгоо, Н.Энхбаярын нэр хүндийн тодотгол эсвэл авилгын эсрэг хийсэн анхааруулга мэтээр тайлбарласан нь жинхэнэ олон улсын сэтгүүл зүйн дүр төрх биш ээ. Сэтгэл хөөрөл, хэтрүүлэл нь манай сэтгүүл зүйн гэм биш зан болжээ. Энэ нь хандив тусламж зээл, айлчлал, гадаад харилцааны үйл явдлын хүрээнд бүр ч тодорхой байдаг хандлага билээ. Үүний шалтгаан нь олон зүйл байгаа боловч "протоколын" мэдээг дэлгэрүүлэх баяжуулах зорилго, бодит байдалтай холбоотой ба сэтгүүлчдийн ажлаа хөнгөвчлэх нэг арга хэмээн үзэх үндэстэй юм.

Харин шууд дүгнэлт ямар нэг үзэл номлол эрх ашгийн нотолгоо болгодог алдаа нь мэдлэг чадвар хомс байдаг эсвэл зориуд зорилготойгоор мэдээллийг гуйвуулж буй үзэгдэл юм. "Дэлхий нийтээр анхаарч байна", "Олон улсын төвшинд сайшаалаа", "Бүс нутгийн тэргүүлэгч удирдагч", "Ц.Элбэгдорж Германыг бишрүүллээ", "О.Цолмонг Япон даяар гайхаж байна" зэрэг дүгнэлт тайлбар нь бодит байдлаас хол зөрөөтэй төдийгүй үр нөлөө, ач холбогдол үгүй "цаас барж цаг идсэн" зүйл болно.

Эцэст нь тэмдэглэхэд олон улсын сэтгүүл зүй нь өсөн нэмэгдэж, өргөжин

тэлж буй үндэсний эрх ашиг, гадаад бодлогын салшгүй нэгэн хэсэг тогтолцоо төдийгүй дэлхийн нийгмийг харах монгол цонх болон төлөвших цаг нэгэнт болжээ. Нөгөө талаар олон улсын сэтгүүл зүй нь задлан шинжилсэн, хэтийн төлөв тодорхойлсон нийтлэлзүйн хандлагыг бичлэгийн төрөл давамгайлсан нийгмийн тэргүүлэгч бүлэг хүрээний харилцаа байх шаардлага эрэлт хэрэгцээ даяарчлал, эдүгээчлэл, дэлхийн шинэ дэг журмын өрнөл хөгжлийн үр дагавар нөхцлөөр бодит зүйл болоод байна. Бидэнд дэлхийг харах, ойлгох, мэдэх, дүгнэх, сэтгүүл зүй хэрэгтэй байна.

Ишлэл

- 1 Grunwald Henry A. 1993. The Post-Cold War Press. Foreign Affairs, Summer, p. 12.
- 2 Lasswell Harold. 1948. Process and Effect of Mass Communication. N.-Y., p. 189.
- 3 Lippman Walter. 1920. Liberty and the News. N.-Y., p. 82.

Ашигласан бүтээлийн жагсаалт

- 1 Grunwald Henry A. 1993. The Post-Cold War Press. Foreign Affairs, Summer.
- 2 Lasswell Harold. 1948. Process and Effect of Mass Communication. N.-Y.
- 3 Lippman Walter. 1920. Liberty and the News. N.-Y.
- 4 Хатингтон Г. 2005. Дэлхийн нийгмийн шинэ дэг журам, иргэншил хоорондын мөргөлдөөн. УБ.
- 5 Тофлер А. 1995. Трета вълна. София.
6. 1994. Монгол Улсын Гадаад Бодлогын үзэл баримтлал. УБ.
7. 1995. Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлал. УБ.